Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1: Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 1 | **Зорилт: 1. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ** | **ОНТ-160,0** | **Сургалтанд хамрагдсан иргэд Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт** | **Сургалтанд хамрагдсан иргэд - 14000 Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт-43,2** | **Сургалтанд хамрагдсан иргэд - 15000 Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт-50,0** | **Сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэд - 33035**<br><br>**Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт-47.4** | **93,3** |
| 1.1 | Нас, сэтгэхүйн онцлогт тохирсон контент, мэдээллийг бэлтгэн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг цахимаар түгээн дэлгэрүүлэх | ОНТ-10.0 | Телевизийн ярилцлага, нэвтрүүлэг, контент, сурталчилгааны тоо | Телевизийн ярилцлага- 2, нэвтрүүлэг- 4, контент-3, сурталчилгаа-10 удаа | Телевизийн ярилцлага- 4 , нэвтрүүлэг- 6, контент-5 сурталчилгаа-14 удаа | ЭМЯ, НЭМҮТ-ийн бэлтгэсэн 13 контентийг Сайхан Монгол тв-тэй хамтран тэгш цагуудад ТВ- ээр иргэд олон нийтэд хүргэн ажиллаж байна. Мөн “Анхдагч зөвлөгөө” иргэдийн эрүүл мэндийн боловсролд зориулсан ажил мэргэжил сурталчилсан 3 удаагийн нэвтрүүлэг, ярилцлага-4, контент-3, цахим сурталчилгааг-6 удаа бэлтгэн иргэдэд хүргэсэн. Үүнд:<br><br>-Хүний папиллома вирусын халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх контент | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -11-14 настай хүүхдүүд болон тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт дархлаажуулалтын контент<br><br>-ЕБС-ийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэг илрүүлэх эрт илрүүлэг үзлэгий ярилцлага<br><br>-Дархлаажуулалт- Ирээдүйн хамгаалалт" товлолын дархлаажуулалтын ач холбогдол ярилцлага<br><br>-24/3 шүдээ зөв угаах контент<br><br>-Хүний папиллома вирусийн халдвараас сэргийлэх дархлаажуулалт ярилцлага<br><br>-Амьсгалын замын халдварт өвчнөөс /Улаанбурхан, контент<br><br>-Гар хөл амны өвчин, Менингит, Салхинцэцэг/ урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл<br>Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.gov.mn болон Булган Эрүүл мэндийн газар нүүр хуудсаар мэдээллийг хүргэн цахим хуудсаар мэдээ, мэдээллийг үнэн зөв хүргэх зорилгоор ЭМБ-д давхардсан тоогоор 212 мэдээллийг цахим хуудсан байршуулж, 42684 хүн цахим хуудсанд хандсан. | |
| 1.2 | Хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол зэрэг анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах мэдээлэл, сургалт, | ОНТ-10.0 | Хамрагдсан хүн амын тоо | 14000 | 15000 | Аймгийн Засаг даргын А/32 тоот захирамжаар "Архи тамхи-Шинэ үеийн сонголт биш" нэрэмжит сарын аяныг жил бүрийн 3-р сард Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчилгааны хамрах хүрээг нэмэгдүүлэх | | | | | зохион байгуулж хэвшээд байна. ЕБС-ийн 8-11-р ангийн 246 сурагчдад тамхи Тамхины үнэнийг илчилье, амттаны цаана хор сэдвээр сургалт, мэдээллийг зохион байгуулж 2 төрлийн санамжийг 432 ширхгийг хэвлэн тараасан. Булган Эрүүл мэндийн газар нүүр цахим хуудсаар хорт зуршил, Буруу хооллолт, Хөдөлгөөний хомсдол таргалалт, халдвар, стресс зэрэг шалтгаан зэрэг сэдвээр 6 төрлийн зөвлөмжит мэдээллийг давхардсан тоогоор 23 удаа цахим хуудсан байршуулж, 12365 иргэн цахим хуудсанд хандсан. “Архи тамхи шинэ үеийн сонголт биш” уриан дор зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, 4 төрлийн постер бэлтгэн цахим хэлбэрээр хүргэсэн. "Дасгал хөдөлгөөн цаг гаргая", аяныг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. “Тэнцвэртэй хооллолт”, “Эрүүл бус хүнсний хэрэглээ” сургалтыг 22 удаа зохион байгуулж, боловсролын 5 байгууллагын 187, Цагдаагийн газрын 30 албан хаагч, 16 сумын эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн 222 иргэнд зохион байгуулсан. Эрүүл хооллолтын 2 төрлийн гарын авлага боловсруулан 174 иргэнд түгээсэн. Эрүүл Монгол хүн, НЭМТ-өөс зарласан “САХАРГҮЙ 30 ХОНОГ CHALLENGE”-д нэгдэж аймгийн хэмжээнд “ДОЛОО ХОНОГИЙН НЭГ ӨДРИЙГ ЧИХЭРТЭЙ” арга хэмжээний удирдамжийг боловсруулан ЭМГ-ын даргын батлуулан ЭМБ-ууд, ЕБС-уудад хүргүүлж, “Сахарын хэрэглээнээс татгалзая”, “Сахарын хэрэглээ” зэрэг 7 төрлийн постор, 3 төрлийн видео бичлэгийг хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар Булган аймгийн ЕБС-ийн 1-р ангийн 1058 суралцагчид нүд, шүд, зүрх гэсэн 3 төрлөөр үзлэгийн үеэр эрүүл хооллолт, чихрийн хэрэглээний талаар мэдээлэл өгч 700 гаруй сурталчилгааны материал тараасан. | |
| 1.3 | Ундны ус, сүү сүүн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах | ОНТ-20.0 | Өрхийн тоо | 0 | 4000 | Иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүний чанарыг хадгалах зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар 2 төрлийн постор байршуулж иргэд олон нийтэд сурталчилан ажилласан. Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 2 эм ханган, 7 эмийн санд “Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль”, ЭМС-ын А/400 дугаар тушаал “Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журам батлах тухай” журамын хэрэгжилтэд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгх ажлыг зохион байгуулж, дэмжлэгт хяналтын дагуу зөвлөмж хүргүүлсэн.<br>Жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд нялхсын болон хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хоол, нялх, балчир хүүхдийн эмчилгээний тусгай сүүн тэжээл, нялх, балчир хүүхдийн ундаа, хооллох хэрэгсэлийг авах үед чанар, аюулгүй байдал, сав, баглаа боодол, шошгололт, хадгалалт, тээвэрлэлтийн байдалд анхаач худалдах авах талаар мэдээллийг 150 гаруй ээж нарт өгсөн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | Ерөнхий боловсролын сургуульд "Шүд угаах цаг" бий болгон хэвшүүлж, амны хөндийн эрүүл ахуй сахих сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | ОНТ-15.0 | Шүдээ угааж хэвшсэн ангийн тоо | 53 | 73 | “Шүд угаах цаг” зохион байгуулах зөвлөмж бичлэгийг Сайхан Монгол тв-тэй хамтран бэлтгэж цахим сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулсан. ЕБС-ын үдийн цай хөтөлбөрийн дараа шүд угаах цагийг 55 ангид бий болгосон. 24/3-Шүдээ зөв угаа-2025 аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 6470 хүүхдийг хамруулж, 3449 хүүхдэд нэмэлт эрдэсжүүлэлт хийсэн. | 100 |
| 1.5 | Аймгийн Засаг даргын нэрэмжит зүрх судас, хоол боловсруулах, хавдрын чиглэлээр нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг сум, багийн түвшинд зохион байгуулах | ОНТ-60.0 | Үзлэг зохион байгуулсан сумдын тоо | Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 9 сум, 1 тосгонд зохион байгуулсан. | 16 сум, 1 тосгонд | Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 8 суманд зохион байгуулж, нийт 2178 иргэнийг хамруулж, 18 иргэнийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэн ажилласан. | 90 |
| 1.6 | Эрүүл мэндийн байгууллагуудын шүдний кабинетийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шүдний цоорлыг бүрэн эмчлэн эрүүлжүүлэх | ОНТ-45.0<br>- | Шүдний кабинет<br>Шүд нь бүрэн эрүүлжсэн хүүхдийн тоо | Баян-агт, Сайхан, Хутаг-өндөр, Хишиг-өндөр сумын эрүүл мэндийн төвүүдэд кабинетийн үйл ажиллагааг тогтмолжсон.<br>5100 | Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн сумын ЭМТ<br>5680 | Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвд шүдний кабинетийн үйл ажилагаа тогтмолжсон. Хялганат тосгоны эмнэлэгт кабинетийн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн. Аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетаар урьдчилан сэргийлэх үзлэг зөвлөгөө мэдээллийг 13246 хүнд үзүүлж, 10011 хүнийг эмчилгээнд хамруулсан байна. Гурванбулаг, Тэшиг “Мишээл сан”-тай хамтран зохион байгуулсан үзлэгт 1-18 насны 1381 хүүхдийг хамруулж, 2999 шүдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Тус үзлэгээр 1-18 настай хүүхдийн дундах цоорлын эмчим буюу ЦЛАШ индек 4,2 байгаа боловч 1-5 насны шүүн шүдэнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6,4, 12-17 насны байнгын шүдэнд 4,8 буюу цоорлын эрчим хамгийн өндөр байна. Орон нутгийн төсвийн 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, Гурванбулаг сумын эрүүл мэндийн төвд шүдний бор машин 1 тус тус хангагдсан. | |
| **2** | **Зорилт: 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, барилга байгууламжийн их засвар, өргөтгөл, шинэчлэлийг хийж, стандартын шаардлагад нийцүүлнэ.** | | **Барилга байгууламжийн тоо**<br>**Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт**<br>**Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт** | **Шинээр баригдсан, их засвар хийсэн барилгын тоо-5**<br>**Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь-90**<br>**Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт-76,2** | **Шинээр баригдсан, их засвар хийсэн барилгын тоо-5**<br>**Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь-92**<br>**Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт-80,0** | **Шинээр баригдсан, их засвар хийсэн барилгын тоо-5**<br>**Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь-93,2**<br>**Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт- 80,0** | **83.3** |
| 2.1 | Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжуудад их засвар хийх | УТ, ОНТ-1,115.3 | Их засвар хийгдсэн барилгын тоо | 4 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентген оношилгоо, яаралтай хүлээн авах, эрчимт эмчилгээ, мэдрэлийн тасгуудын засвар, Тэшиг сумын ЭМТ | 2025 оны орон нутгийн төсвийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын Б блокийн хэсэг 350.0 сая төгрөг, Хангал сумын ЭМТ-ийн барилгын засвар 305.0 сая төгрөг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засвар 400.0 сая төгрөг, Сайхан сумын ЭМТ-ийн 2 барилгыг ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил 68.0 сая төгрөг, Могод сумын ЭМТ-ийн морго, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 104.0 сая төгрөг, Булган сумын “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн дулаан, цэвэр усны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шугамыг төвлөрсөн системд холбох ажил 300.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн барилга 2 барилгад лифт угсарч суурилуулах ажил 400.0 сая төгрөгийн барилгын засварын ажлууд тус тус батлагдсан. Могод сумын ЭМТ-ийн морго, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 100% дууссан. Нэгдсэн эмнэлгийн 2 барилгад лифт суурилуулах ажлын гүйцэтгэгчээр “Оакс инженеринг” ХХК шалгарч угсралтын ажил 70%-тай явагдаж байна. Хангал сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлын гүйцэтгэл 60%, “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн барилгыг төвлөрсөн инженерийн шугамд холбох ажил, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлуудын тендер шалгаруулалт үнэлгээний шатанд явж байна. Сайхан сумын ЭМТ-ийн ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил эхлээд байна. | |
| 2.2 | Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах | ОНТ-200.0 | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 90 | 92 | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 192.0 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сумын эрүүл мэндийн төвд 8 нэр төрлийн 16 ширхэг Мобайл технологийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Улсын төсвийн 126.0 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар 17 сумын 18 эрүүл мэндийн байгууллагууд, Сайхан сумын ЭМТ-д 35.0 сая төгрөгийн ЭХО аппаратаар тус тус хангагдсан. Орон нутгийн төсвийн 160.0 сая төгрөгийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт гемодиализын 2 аппарат, шүдний тоног төхөөрөмж 1, Гурванбулаг сумын ЭМТ-д шүдний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бор машин 1 тус тус хангагдсан. Аймгийн эрүүл мэндийн салбарт 2025 оны эхний хагас жилийн байдлаар тоног төхөөрөмжийн стандарт хангалт 93.2%-д хүрсэн. | |
| 2.3 | Эрүүл мэндийн байгууллагуудыг түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах | ОНТ-360.0 | Түргэн тусламжийн автомашины хангалт | Аймгийн Нэгдсэн эмнэлэг-2, сумдын Эрүүл мэндийн төвүүд 11 автомашинаар хангагдсан. | Гурванбулаг Бүрэгхангай Хутаг-өндөр Орхон | Гурванбулаг, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Орхон сумдын эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашины саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. ЭМЯ-наас автомашины хангалтыг энэ оны 09 сард багтаан нийлүүлэхээр мэдэгдсэн. Хугацаа болоогүй. | 50 |
| 3 | **Зорилт: 3. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэхэд чиглэсэн “Эрүүл Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.** | ОНТ-150 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 0 | 70 | **Аймгийн ИТХ-ын 2025 оны VI/32 дугаар тогтоолоор “Эрүүл Булган” хөтөлбөрийг батлуулж, орон нутгийн төсвөөс 180.0 сая төгрөг батлуулсан. Хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.** | **90** |
| 3.1 | "Эрүүл Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | ОНТ-150 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 0 | 70 | "Эрүүл Булган" хөтөлбөрийг 4 зорилтын 47 арга хэмжээг төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд:<br><br>- Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан Нэгдсэн эмнэлэгт хавдрын хими, хөнгөвчлөх эмчилгээний 9 ортой тасгийг байгуулсан. Тасагт нэн шаардлагатай байгаа химийн эмчилгээний эмчийг ХСҮТ-өөс 6 сарын хугацаатай ажиллуулахад бэлэн болсон.<br><br>- "Шүд угаалтын аварга шалгаруулах" тэмцээн зохион байгуулан, 21 сургуулийн 144 хүүхэд оролцож, эцэг эх, сурагчид, багш нарын амны хөндийн эрүүл мэндийг сахих, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгаалах мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн.<br><br>- Хорт хавдар өвчнөөс сэргийлэх хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх 1 сарын аяныг зохион байгуулан, 16 сум, 1 тосгоны 19 сургуулийн багш, 6-р ангийн суралцагчид, тэдний эцэг эхчүүд, асран хамгаалагч 1690 хүнийг сургалтад хамруулан, 263 хүүхдийг нөхөн дархлаажуулж, хамралт 22.4хувиар нэмэгдэж, хамрагдвал зохих хүүхдийг 63.1хувийг хамруулллаа<br><br>- Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 8 суманд зохион байгуулж, нийт 2178 иргэнийг хамруулж, 18 иргэнийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэн ажилласан. | |
| **Зорилго 2. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | |
| **4** | **Зорилт: 4. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэн хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.** | **УТ, ОНТ-655** | **ЕБС-ийн хамран сургалт СӨБ-ын хамран сургалт Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсрол хамрагдалт** | **ЕБС-ийн хамран сургалт-86,96 СӨБ-ын хамран сургалт -84,28 Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсрол хамрагдалт-89,3** | **ЕБС-ийн хамран сургалт-89,46 СӨБ-ын хамран сургалт-86,3 Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсрол хамрагдалт-90,3** | **Ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 88.28 хувь, бүлэг дүүргэлт 25 ба стандарт түвшинд байна.<br><br>Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 84.2 хувьтай, бүлэг дүүргэлт 24-тэй байна.<br><br>Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт 90 хувьтай ба өмнөх оноос 0.7 хувь буюу 10 суралцагчаар нэмэгдсэн байна.** | **93.3** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Тэгш хамруулах боловсролыг дэмжих зорилгоор ялгаатай хэрэгцээтэй хүүхэд суралцаж буй цэцэрлэг, сургуулийн орчинг сайжруулах | **ОНТ-100** | Танхимын тоо | 1 | 2 | Булган аймгийн Рашаант суманд 75 ортой Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг Артуус ХХК 2,433.2 сая төгрөгөөр хийж байгаа ба ажлын явц 70 хувьд хүрээд байна. 2025 оны 3-р улиралд ашиглалтанд орно. Булган аймгийн Сайхан сумын сургуулийн барилгын 320 суудалтай барилгын ажлыг "Туст эр констракшн ХХК" 5,078.8 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 10 хувьтай явагдаж байна. Булган аймгийн Баян-Агт сумын сургуулийн 320 хүүхдийн суудалтай барилгыг "Даацын цамхаг ХХК" 6,947.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хийгдэх ба ажлын явц 10 хувьтай явагдаж байна. | 90 |
| 4.2 | Цэцэрлэгийн тоглоом, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх | УТ, ОНТ-500 | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 26,5 | 42,1 | 2025 оны эхний хагас жилд орон нутгийн төсвийн 385.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн тоглоом, хөгжим, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангасан. Үүнд:<br><br>22 цэцэрлэгт 28.6 сая төгрөгөөр сургуулийн өмнөх боловсрол олгох багц хэрэглэгдэхүүн,<br><br>Булган сумын 1,2,3,4,6,7 дугаар цэцэрлэгт 113 сая төгрөг, Рашаант, Сэлэнгэ сумын цэцэрлэгт 34.0 сая төгрөгөөр steam хэрэглэгдэхүүн,<br><br>Булган сумын 4 дүгээр цэцэрлэгт 20.0 сая төгрөгөөр зөөлөн эдлэл, 6 дугаар цэцэрлэгт 19.3 сая төгрөгөөр тоног төхөөрөмжөөр хангасан.<br><br>Мөн Баян-Агт, Баяннуур, Бугат, Бүрэгхангай, Тэшиг, Хутаг-өндөр сумын цэцэрлэгүүдэд орон нутгийн хөгжлийн сангаас Хөгжим, техник | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгсэл, засвар үйлчилгээнд 61.5 сая, Хутаг-Өндөр сумын Хонгор багт 20 хүүхдийн цэцэрлэгийн барилгад 109,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. | |
| 4.3 | "Шүд угаах цаг" үйл ажиллагааг хэрэгжүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх | ОНТ-55 | Орчин нөхцөл бүрдсэн сургуулийн тоо | 0 | 5 | Ерөнхий боловсролын 22 сургуулийн 38 хичээлийн байранд 55 анги танхимд шүд угаах орчин, нөхцлийг өөрсдийн нөөцөд тулгуурлан бүрдүүлсэн. | 100 |
| 5 | **Зорилт: 5. Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан, чадварлаг багшийг бэлтгэнэ.** | ОНТ-111 | Сургалтанд хамрагдсан багш, ажилчид Туршлага судалсан багш, ажилчид | Сургалтанд хамрагдсан багш, ажилчид-1440 Туршлага судалсан багш, ажилчид-60 | Сургалтанд хамрагдсан багш, ажилчид-1500 Туршлага судалсан багш, ажилчид-65 | Боловсролын ерөнхий газраас зохион байгуулдаг үндсэн сургалтад судлагдахууны 100 гаруй багш, олон улсын чанарын шаардлага хангасан Мозайк цахим платформын сургалтад 30 багш хамрагдсан байна. Ажлын байрны сургалтад 10 чиглэлийн хүрээнд давхардсан тоогоор 1800 орчим багш хамрагдсан.<br>Булган аймгийн Хутаг-Өндөр суманд "Сайн хичээл" аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж 20 багийн 300 багш хамрагдаж туршлага солилцлоо. | 72.5 |
| 5.1 | Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах, танхимын ба танхимын бус сургалтыг зохион байгуулах багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургагч багшийг бэлтгэх, чадваржуулах | ОНТ-15 | Бэлтгэгдсэн багшийн тоо | 8 | 11 | 2025 оны эхний хагас жилд ялгаатай хэрэгцээт боловсролын чиглэлээр сургалтад 3 багш хамрагдан 11 багш бэлтгэгдсэн. Сургуулийн өмнөх боловсролын багш нарын сургалт тодорхой шалтгааны улмаас зохион байгуулалт хойшилсон. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт 90 хувьтай ба өмнөх оноос 0.7 хувь буюу 10 суралцагчаар нэмэгдсэн байна. | 90 |
| 5.2 | Шилдэг багш, удирдах ажилтан, албан хаагчдыг шалгаруулах, урамшуулах | ОНТ-11 | Урамшуулсан албан хаагчийн тоо | 11 | 11 | Аймгийн ИТХ-ын 2025 оны VIII/56 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох, урамшуулал, дэмжлэг үзүүлэх журам”-д элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноо авсан сурагчдыг | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэсэн багш нарыг урамшуулахаар тусгасан. | |
| 5.3 | "Хүүхэд төвтэй багшлахуйн арга зүй"-н чиглэлээр гадаад, дотоодод туршлага солилцох үйл ажиллагаанд хамруулах | ОНТ-25 | Туршлага солилцох үйл ажиллагаанд хамрагдсан багшийн тоо | 60 | 20 | “Багшлахуйн баясгалан” НҮТББ-тай хамтран ажиллах гэрээний дагуу 11 сургуулийн 435 багш удирдлагыг “Сургалтын хөтөлбөрийг хүүхэд төвтэй хэрэгжүүлэх менежмент ба хамтын ажиллагааны аргачлал”-д сургасан. Дээрх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. | 100 |
| 5.4 | Аймаг, Бүс, Улсын чанартай олимпиад уралдаан тэмцээн, элсэлтийн шалгалтад өндөр амжилт үзүүлсэн судлагдахууны багшийг урамшуулах /10 судлагдахуун тус бүрээс 3 багш урамшуулах/ | ОНТ-60 | Урамшуулан дэмжсэн багшийн тоо | 30 | 30 | Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноогоор 600-аас дээш хэмжээст оноотой 4 судлагдахууны багшид дэмжлэг үзүүлсэн. Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноогоор 600-аас дээш хэмжээст оноотой багшид 1.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 50 |
| 6 | **Зорилт: 6. Дэлхийд өрсөлдөх чадвартай иргэнийг бэлтгэх зорилгоор математик, мэдээлэл зүй, англи хэлний судлагдахууныг түлхүү анхаарч “Код бичих хөтөлбөр”, “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.** | | **Англи хэлний сурлагын чанар Математикийн сурлагын чанар Мэдээлэл зүйн сурлагын чанар** | **Англи хэлний сурлагын чанар-41% Математикийн сурлагын чанар-37,6% Мэдээлэл зүйн сурлагын чанар-43,3%** | **Англи хэлний сурлагын чанар-42% Математикийн сурлагын чанар-39% Мэдээлэл зүйн сурлагын чанар-48,3%** | **Англи хэлний сурлагын чанар-49,8% Математикийн сурлагын чанар-36,8% Мэдээлэл зүйн сурлагын чанар-47,0%** | **75** |
| 6.1 | “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ-130 | Хөтөлбөрийн хэрэгжилт | 0 | 70 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хурлын 2025 оны VI/33 дугаар тогтоолоор "Анли хэлтэй Булган" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд "Монголын англи хэлний академи"-тай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг байгуулан, “Англи хэлний ач холбогдол ба хичээлээ хэрхэн үр дүнтэй заах вэ?” сэдэвт сургалтыг Боловсролын газрын удирдлага, мэргэжилтэн, ерөнхий боловсролын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн захирал, сургалтын менежер, англи хэлний багш, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад “Англи хэл ба тэтгэлэгт хамрагдах боломж танд бий” сэдэвт сургалт орж, мөн сумдын Засаг дарга нарт “Англи хэл бол амьдралын витамин”, мөн төрийн албан хаагчдад “Англи хэлийг яаж хурдан сурах вэ?” сэдэвт сургалт зохион байгуулсан. | |
| 6.2 | “Код бичих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ-50 | Хөтөлбөрийн хэрэгжилт | 0 | 70 | Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн багш нараас саналыг авч, “Код бичих” хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэр бэлтгэж байна. | 50 |
| 7 | **Зорилт: 7. Жил бүр 12 дугаар анги төгсөгчдөөс аймагт нэн шаардлагатай мэргэжлээр гадаад, дотоодын их дээд сургуульд суралцах боломжийг бүрдүүлэн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.** | **ОНТ-947,6** | **Дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутан Гадаадын тэтгэлэгт хамрагдсан оюутан** | **Дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутан-74 Гадаадын тэтгэлэгт хамрагдсан оюутан-87** | **Дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутан-94 Гадаадын тэтгэлэгт хамрагдсан оюутан-89** | **"Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ-ын VII хуралдаанаар хэлэлцүүлэн, VIII/56 дугаар тогтоолоор батлуулсан.** | **90** |
| 7.1 | Гадаад, дотоодын их, дээд сургуульд элссэн оюутнуудад тэтгэлэг олгох | ОНТ-180 | Дотоодын тэтгэлэгт хамрагдсан оюутан | 74 | 94 | "Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ-ын VII хуралдаанаар хэлэлцүүлэн, VIII/56 дугаар тогтоолоор батлуулсан. Журмын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр эхний 20-д жагссан сурагчдаас, орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж төгсөөд орон нутагтаа ажиллах хүсэлтэй сурагчид тэтгэлэг олгогдоно. Тэтгэлэгийг 3,4 дүгээр улиралд багтаан олгоно. | 90 |
| | | ОНТ-767,6 | Гадаадын тэтгэлэгт хамрагдсан оюутан | 87 | 89 | | |
| **Зорилго 3. Нийтийн биеийн тамир спортыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, үндэсний болон өвлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **8** | **Зорилт:8. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" төлөвлөгөө болон "Спорт бүжиг" хөтөлбөрийг шинээр боловсруулан хэрэгжүүлнэ.** | **УТ, ОНТ** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь** | **Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжихэд чиглэсэн 16 арга хэмжээг зохион байгуулж, 27000 иргэдийг хамруулж, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх төлөвлөгөөг 90 хувьтай хэрэгжүүлсэн.** | **Иргэдэд чиглэсэн 18 арга хэмжээг зохион байгуулж, 28000 иргэдийг хамруулсан байна. "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх төлөвлөгөөг 90-ээс доошгүй хувьтай хэрэгжүүлж, "Спорт бүжиг" хөтөлбөрийг 70-аас доошгүй хувьтай хэрэгжүүлнэ.** | **Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор 2025 оны хагас жилийн байдлаар нийт 9 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 10000 гаруй иргэдийг хамруулан оролцуулж, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тамирчдын амжилт, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны хагас жилийн байдлаар орон нутгийн төсвийн 78.0 сая төгрөгийн санхүүжилтээр улсын чанартай спортын томоохон тэмцээн уралдаануудыг амжилттай зохион байгууллаа.Аймгийн хэмжээнд ахмад настнуудын эрүүл мэндийг дэмжих, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шугаман бүжгийн 5 хамтлаг тогтмол үйл ажиллагаа явуулж байна.** | **92.5** |
| 8.1 | Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжихэд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах | ОНТ-40.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо | Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжихэд чиглэсэн 16 арга хэмжээг зохион байгуулж, 27000 иргэдийг хамруулсан. | Иргэдэд чиглэсэн 18 арга хэмжээг зохион байгуулж, 28000 иргэдийг хамруулсан байна. | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор 2025 оны хагас жилийн байдлаар нийт 9 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 10000 гаруй иргэдийг хамруулан оролцуулж, орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг зарцуулан ажиллаа. Тухайлбал: Хойд бүсийн иргэдийн спорт наадмын шигшээ болон анхан шатны тэмцээнийг 7 төрлөөр амжилттай зохион байгуулж, 670 гаруй иргэн хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Мөн"Идэвхтэй алхалтад – Цаг гаргая" | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аяны хүрээнд өдөр бүр 30 минут идэвхтэй алхаж, 10,000 алхам хийх уриалгыг хэрэгжүүлж, шугаман бүжиг, цэнгээнт бүжиг, ахмадын бүжиг, усан бассейн, фитнес, софт волейбол зэрэг хичээлүүдийг тогтмол явуулж, усан бассейн 168, фитнесээр 225 хүн хичээллэж байна. | |
| 8.2 | “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх” жилийн төлөвлөгөөг шинээр боловсруулан хэрэгжүүлэх. | УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр 120.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт | Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай хэрэгжүүлсэн. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьтай хэрэгжүүлсэн байна. | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тамирчдын амжилт, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны хагас жилийн байдлаар орон нутгийн төсвийн 78.0 сая төгрөгийн санхүүжилтээр улсын чанартай спортын томоохон тэмцээн уралдаануудыг амжилттай зохион байгууллаа. Тухайлбал: Хөвгүүдийн өсвөрийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээнд 65 багийн 800 гаруй тамирчин, самбо бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 16 багийн 122 тамирчин хүч чадал, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Мөн Монголын Хүүхдийн спортын VIII их наадмын өвлийн спортын төрлийн гүйлтийн тэшүүрийн төрөлд Булган аймгийн өсвөрийн шигшээ баг тамирчид алтан медаль 5, мөнгөн медаль 3, хүрэл медаль 6 нийт 14 медаль хүртэж, багийн дүнгээр 3 байр, гүйлтийн цанын төрөлд цанын өсвөрийн шигшээ баг тамирчид оролцож алтан медаль 2, 8 мөнгөн медаль хүртэж, багийн дүнгээр 2 байр, Ази болон далайн орнуудын аварга шалгаруулах самбо бөхийн М6 ангилалд МУ-ын гавьяат дасгалжуулагч, өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагч Ш.Эрдэнэ-Очир алтан медаль, шавь Б.Баасан-Очир хүрэл медаль, Монголын Хүүхдийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | спортын зуны VIII их наадмын шигшээ тэмцээнд өсвөрийн 143 баг, тамирчид, спортын 15 төрлөөр оролцож, алтан медаль 2, мөнгөн медаль 13, хүрэл медаль 5 нийт 20 медаль авч багийн дүнгээр 11 байранд шалгарсан амжилт үзүүллээ. | |
| 8.3 | “Спорт бүжиг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ-10.0 | Хөтөлбөрийн хэрэгжилт | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийг 70-аас доошгүй хувьтай хэрэгжүүлсэн байна. | Аймгийн хэмжээнд ахмад настнуудын эрүүл мэндийг дэмжих, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шугаман бүжгийн 5 хамтлаг тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал: Булган суманд "Жигүүр-1", "Жигүүр-2", "Цоглог", "Мөрөөдөл" шугаман бүжгийн хамтлаг, Дашинчилэн суманд "Ахмадын золбоо" шугаман бүжгийн хамтлагууд амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр хамтлагуудад нийт 72 ахмад настан идэвхтэй хамрагдан хичээллэж байна. | 100 |
| 8.4 | Спортын холбоо, клубтэй хамтран спортын авьяастнуудыг нээн илрүүлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. | ОНТ-10 | Хамтран ажилсан холбоодын тоо, секц, дугуйланд хамрагдаж байгаа хүүхдийн тоо | 8 спортын холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 23 төрлийн секц, дугуйланд 3124 хүүхэд хамрагдсан | 12 спортын холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 24 төрлийн секц, дугуйланд 3500 хүүхэд тогтмол хичээллэдэг болсон байна. | 12 спортын холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, Аймгийн хэмжээнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, спортын олон төрөлд сонирхолтой иргэдийг тогтмол хамруулах зорилгоор волейбол, сагсан бөмбөг, бокс, жудо бөх, самбо бөх, ширээний теннис, такеквондо, буудлага, хөнгөн атлетик, шатар, үндэсний бөх, шагайн харваа зэрэг 12 төрлөөр албан ёсны 25 секц, дугуйлан тогтмол үйл ажиллагаа явуулж, 3200 гаруй хүүхэд тогтмол хичээллэж байна. | 100 |
| 9 | **Зорилт:9. Үндэсний болон өвлийн спортыг хөгжүүлж, тамирчдыг дэмжиж, амжилтыг ахиулна. Улс, бүсийн чанартай** | **УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр** | **Зохион байгуулсан арга** | **Улс бүсийн чанартай 54 удаагийн** | **Үндэсний спортын** | **2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд улс чанартай 2 тэмцээнийг амжилттай** | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **чанартай уралдаан, тэмцээнийг зохион байгуулж, тамирчдын оролцоог нэмэгдүүлнэ.** | **280.0** | **хэмжээний тоо, Тэмцээн уралдаанд оролцсон тамирчдын тоо, амжилт гаргасан эсэх** | **уралдаан, тэмцээнд 2478 тамирчин оролцож 334 медаль хүртэж, амжилт өмнөх жилээс 14 хувиар өссөн. Улсын чанартай 3 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, 600 гаруй тамирчдыг хамруулсан.** | **төрлөөр 39 төрөл, өвлийн спортын төрлөөр 5 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, тамирчдын оролцоог нэмэгдүүлж, тамирчдыг дэмжин амжилтыг ахиулсан байна. Улсын чанартай 2-оос доошгүй тэмцээн уралдааны зохион байгуулсан байна.** | **зохион байгуулж, 1280 тамирчин хамрагдан 78.0 сая төгрөгийг зарцууллаа. Үндэсний бөх, сур, шагайн харваа, мөсний сур, мөсний шагайн харвааг аймгийн хэмжээнд хөгжүүлж, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор таван спортын холбоотой хамтран олон арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Өсвөрийн шигшээ багийн тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнээс нийт 106 медаль, Монголын хүүхдийн спортын наадмын өвөл, зуны төрөлд нийт 56 медаль хүртэж багийн дүнгээр XI байр “Шилдэг” таван аймгийн нэгээр шалгарсан байна.** | |
| 9.1 | Үндэсний спортын төрлийг хөгжүүлж, хичээллэсдийн тоог нэмэгдүүлэх /үндэсний бөх, сур, шагай/ | ОНТ-40.0 | Зохион байгуулсан тэмцээн уралдааны тоо, оролцсон тамирчдын тоо | 38 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, 2322 тамирчин оролцсон | 39 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, 2422 тамирчдыг хамруулсан байна. | Үндэсний бөх, сур, шагайн харваа, мөсний сур, мөсний шагайн харвааг аймгийн хэмжээнд хөгжүүлж, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор таван спортын холбоотой хамтран олон арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тухайлбал: Үндэсний сурын спортыг хөгжүүлэх хүрээнд Дайчин вангийн мэргэд сурын холбоотой хамтран Баян-Агт сумнад аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, Орхон, Хөвсгөл, Булган аймгийн 100 гаруй харваач, үндэсний сурын нээлтийн харвааанд 80 харваач, улсын нээлтийн харваанд орон нутаг, аймгаа төлөөлөн 18 харваач амжилттай оролцлоо. Мөн үндэсний шагайн харвааг хөгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан аймгийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аварга шалгаруулах тэмцээнд 20 багийн 160 харваач, сар шинийн харвааанд 22 багийн 176 харваач, Монгол эр цэргийн баярт зориулсан харвааанд 29 багийн 232 харваач, Өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 9 багийн 72 харваач, “Хангинахуйн шугуйн шагайн тойром” арга хэмжээнд 24 багийн 192 харваач оролцож, нийт 832 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. | |
| 9.2 | Улсын чанартай тэмцээн уралдааныг аймаг орон нутагт зохион байгуулах (Волейболын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн) | УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр 100.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, оролцсон тамирчдын тоо | Улсын чанартай 3 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, 600 гаруй тамирчдыг хамруулсан. | 2-оос доошгүй улсын чанартай тэмцээн уралдааныг зохион байгуулж, 900 гаруй тамирчдыг хамруулсан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд улс чанартай 2 тэмцээнийг амжилттай зохион байгуулж, 1280 тамирчин хамрагдан 78.0 сая төгрөгийг зарцуулсан. Тухайлбал: 2025 оны хөвгүүдийн өсвөрийн “Улсын аварга шалгаруулах волейболын тэмцээн”-ийг Булган суманд зохион байгуулагдаж 65 багийн 800 гаруй тамирчид, Монгол улсын гавьяат дасгалжуулагч, Ази тивийн аварга, ОУХМастер Ш.Эрдэнэ-Очирын нэрэмжит Залуучуудын Улсын аварга шалгаруулах самбо бөхийн тэмцээн зохион байгуулж, 16 багийн 122 тамирчид өрсөлдсөн. | 100 |
| 9.3 | Өвлийн спортын төрлийг хөгжүүлж, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх | ОНТ-50.0 | Зохион байгуулсан тэмцээн уралдааны тоо, оролцсон тамирчдын тоо | Төрөлжсөн 3 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, 70 гаруй тамирчдыг хамруулсан. | Төрөлжсөн 5-аас доошгүй тэмцээн уралдааныг зохион байгуулж, 100 гаруй тамирчдыг хамруулсан байна | Өвлийн спорт мөсний сур харваа, мөсний шагайн харвааг хөгжүүлэн сурталчлах зорилгоор жил бүр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, улс бүсийн тэмцээнд баг тамирчид амжилттай оролцож байна. Мөсний шагайн харвааг Булган суманд зохион байгуулж 7 байгууллага, 4 сумын 29 харваач, Орхон сумын “Орхон” голд Мөсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж Орхон, Булган, Хөвсгөл, Дундговь, Дархан, Төв аймгийн нийт 86 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9.4 | Аймгийн өсвөрийн шигшээ багийг үе шаттайгаар дэмжин, Улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх. | УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр<br>90 | Тэмцээн уралдаанд оролцсон тоо, амжилт гаргасан эсэх | Улс бүсийн чанартай 54 удаагийн уралдаан, тэмцээнд 2478 тамирчин оролцож 334 медаль хүртэж, амжилт өмнөх жилээс 14 хувиар өссөн. | 50-аас доошгүй төрлийн тэмцээн уралдаанд оролцож, өсвөрийн шигшээ багийг дэмжин,амжилт ахисан байна. | Аймгийн өсвөрийн шигшээ багийг спортын 12 төрлөөр байгуулан спортын холбоодтой хамтран ажиллах гэрээг байгуулан, тэмцээн уралдааныг зохион байгуулж, бүс, олон хот, нэрэмжит, улс, олон улс, тив, дэлхийн тэмцээнүүдэд тамирчдыг оролцуулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнээс нийт 106 медаль, Монголын хүүхдийн спортын наадмын өвөл, зуны төрөлд нийт 56 медаль хүртэж багийн дүнгээр XI байр “Шилдэг” таван аймгийн нэгээр шалгарсан байна. | 100 |
| **Зорилго 4. Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэн, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, үндэсний болон орчин үеийн соёлыг түгээн дэлгэрүүлнэ.** | | | | | | | |
| **10** | **Зорилт: 10. Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх замаар орчин үеийн соёл урлагийг түгээн дэлгэрүүлнэ.** | **УТ, ОНТ-223** | **Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөө болон “Амьд хөгжим” хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн албан хаагчдын тоо, урамшуулсан шилдэг бүтээл болон уран бүтээлчдийн тоо** | **Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 хувьтай хэрэгжүүлж, 2 албан хаагчид мэргэшүүлэх сургалтад хамрагдхад дэмжлэг үзүүлсэн.** | **Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөө болон“Амьд хөгжим” хөтөлбөрийг 70-аас доошгүй хувиар хэрэгжүүлж, мэргэшүүлэх сургалтад хамрагдах 2 албан хаагчид дэмжлэг үзүүлж, 2-оос доошгүй шилдэг бүтээл болон уран бүтээлчдийг урамшуулна.** | **“Бүх нийтийн соёлын боловсрол II” арга хэмжээний хүрээнд бүх нийтийн соёлын боловсрол олгох 4 зорилт, 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулж, 12 арга хэмжээг хэрэгжүүлэн 20,300 хүнд хүргэж, 2025 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөөг 63.1 хувьтай хэрэгжүүлэн ажиллаа."Амьд хөгжим" хөтөлбөрийн хүрээнд аймгийн 16 сум, 1 тосгоны ерөнхий боловсролын сургууль, Соёлын төвөөс хөгжмийн зэмсэг, хүний нөөцийн судалгаа, хөгжмийн сургалтын төвүүдээс хөгжмийн зэмсгийн үнийн судалгааг нэгтгэн боловсрууллаа. Мэргэжлийн бус 41 ажилтнаас 12 ажилтан нь Соёл урлагийн их сургууль, Сити их сургуулийн эчнээ ангид суралцаж байгаа бөгөөд тэднийг мэргэжлийн ажилтан болгон бэлтгэхэд байгууллагууд дэмжлэг үзүүлэн, суралцах хугацаанд нь цалинтай чөлөө олгож байна. Шилдэг бүтээл болон Улс, Олон улсын чанартай** | **85** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийг урамшуулах журмын төслийг боловсруулан ажиллаа.** | |
| 10.1 | Бүх нийтийн соёлын боловсролын олгох төлөвлөгөөг шинээр боловсруулан хэрэгжүүлнэ. | УТ, ОНТ-50.0 | Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 хувьтай хэрэгжүүлсэн. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70-аас доошгүй хувьтай хэрэгжүүлсэн байна. | “Бүх нийтийн соёлын боловсрол II” арга хэмжээний хүрээнд бүх нийтийн соёлын боловсрол олгох 4 зорилт, 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Утга зохиол, үндэсний бичиг соёлоор дамжуулан бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, урлаг, уран бүтээлээр дамжуулан бүх нийтэд гоо зүйн боловсрол олгох, түүх соёлын дурсгал, соёлын өвийг таниулах замаар үндэсний соёлын дархлаатай иргэдийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх олон талт сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэн 20,300 хүнд хүргэж, 2025 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөөг 63.1 хувьтай хэрэгжүүлэн ажиллаа. | 100 |
| 10.2 | “Амьд хөгжим” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТ-150.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Булган сумын соёлын ордонд гитар хөгжмийн дугуйланд 76 хүүхэд хичээллэж байна. | Хөтөлбөрийг 70-аас доошгүй хувьтай хэрэгжүүлнэ. | "Амьд хөгжим" хөтөлбөрийн хүрээнд аймгийн 16 сум, 1 тосгоны ерөнхий боловсролын сургууль, Соёлын төвөөс хөгжмийн зэмсэг, хүний нөөцийн судалгаа, хөгжмийн сургалтын төвүүдээс хөгжмийн зэмсгийн үнийн судалгааг нэгтгэн боловсруулла. Тус судалгаанд үндэслэн хөтөлбөрийн төсөл, сургагч багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө, сумдад ажиллах зохион байгуулалт, хөгжмийн зэмсэг худалдан авахад шаардагдах төсөв зэргийг боловсруулж, холбогдох бэлтгэл | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлыг ханган ажиллав. Соёлын салбарын албан хаагчид болон хөгжмийн багш нарын оролцоотойгоор нийт 4 удаагийн хэлэлцүүлэг, ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, хөтөлбөрийн төслийг Аймгийн ИТХ-ын хүний хөгжил, нийгмийн салбар хорооны хурал, зөвлөлийн хурал, ИТХ-ын 4 дүгээр сарын ээлжит хуралдаанд тус тус танилцуулсан. ИТХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлуулсан. | |
| 10.3 | Соёл урлагийн ажилтнуудыг гадаад дотоодод мэргэшүүлэх, давтан сургах ажлыг ээлж дараатай зохион байгуулна. | ОНТ-8.0 | Дэмжлэг үзүүлсэн албан хаагчдын тоо | 2 албан хаагчид мэргэшүүлэх сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлсэн. | 2-оос доошгүй албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлсэн байна. | Аймгийн соёл, урлагийн салбарт нийт 184 ажилтан ажиллаж байна. Үүнээс мэргэжил шаардагдах 145 орон тоонд 71.1 хувь буюу 104 мэргэжлийн, 41 мэргэжлийн бус ажилтан байна Мэргэжлийн бус 41 ажилтнаас 12 ажилтан нь Соёл урлагийн их сургууль, Сити их сургуулийн эчнээ ангид суралцаж байгаа бөгөөд тэднийг мэргэжлийн ажилтан болгон бэлтгэхэд байгууллагууд дэмжлэг үзүүлэн, суралцах хугацаанд нь цалинтай чөлөө олгож байна. | 100 |
| 10.4 | Шилдэг бүтээл болон улсын, олон улсын чанартай уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийг урамшуулах | ОНТ-15.0 | Урамшуулсан шилдэг бүтээл болон уран бүтээлчдийн тоо | - | 2-оос доошгүй шилдэг бүтээл болон уран бүтээлчдийг урамшуулна | Шилдэг бүтээл болон Улс, Олон улсын чанартай уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийг урамшуулах журмын төслийг боловсруулан Боловсролын газар, Театр, Сумдын соёлын төвүүд болон төвийн боловсролын болон соёлын байгууллагуудын удирдлага, урчуудын эвлэл, зохиолчдын эвлэлийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж журмын төсөлд санал авч ажиллаа. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | **Зорилт: 11. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлан таниулж, Соёл, урлагийн үзвэр, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн соёл урлагийн тогтвортой хөгжлийг хангана.** | **УТ, ОНТ-415 Төсөл хөтөлбөр** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо, Тоног төхөөрөмжийн хангалтын хувь,** | **24 арга хэмжээнд, 25000 иргэдийг хамруулж, нүүдэлчин Монгол – 2024 арга хэмжээнд Булган аймгаас 40 хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид амжилттай оролцсон. Мэргэжлийн урлагийн байгууллагын тоног төхөөрөмжийн хангалтыг 70 хувьд хүргэж, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчилсан 2 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргүүлсэн.** | **26-аас доошгүй арга хэмжээнд 26000 иргэдийг хамруулж, тоног төхөөрөмжийн хангалтыг 73 хувьд хүргэнэ. Нүүдэлчин Монгол” фестиваль арга хэмжээнд 40-45 хүний бүрэлдэхүүнтэй баг төлөөлөн оролцсон байна.** | **Утга зохиол, үндэсний бичиг соёлоор дамжуулан бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, урлаг, уран бүтээлээр дамжуулан бүх нийтэд гоо зүйн боловсрол олгох, түүх, соёлын дурсгалт газрууд болон соёлын өвийг таниулах замаар үндэсний соёлын дархлаатай иргэдийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зэрэг 12 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 20,300 хамруулллаа. Хөгжимт жүжгийн театрын зөөврийн лед дэлгэц нийлүүлэх ажлын хүрээнд 100.0 сая төгрөгийн өртөг бүхий техникийн тодорхойлолт болон холбогдох материалыг бүрдүүлж, худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, техникийн тодорхойлолтын дагуу тендерийн шалгаруулалт зохион байгуулагдаж, "Амжилтын нар" ХХК шалгарсан. “Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль”-д аймаг, орон нутгаа төлөөлөн оролцохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Аймгийн нутаг дэвсгэрт орших Улсын болон аймгийн хамгаалалтад байх нийт 53 дурсгалаас 50 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах чиглэлээр гуравласан гэрээ байгуулсан.** | **92.5** |
| 11.1 | Хүн амын онцлог хэрэгцээнд нийцсэн соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулна | ОНТ-250.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо | 24 арга хэмжээнд, 25000 иргэдийг хамруулсан. | 26-аас доошгүй арга хэмжээнд 26000 иргэдийг хамруулна. | Аймгийн хэмжээнд бүх нийтийн соёлын боловсролыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн соёлын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор 4 зорилт, 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус ажлын хүрээнд утга зохиол, үндэсний бичиг соёлоор | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дамжуулан бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, урлаг, уран бүтээлээр дамжуулан бүх нийтэд гоо зүйн боловсрол олгох, түүх, соёлын дурсгалт газрууд болон соёлын өвийг таниулах замаар үндэсний соёлын дархлаатай иргэдийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зэрэг 12 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 20,300 иргэнд хүрч ажилласан бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний гүйцэтгэлийг 63.1 хувьтай хэрэгжүүлээд байна. | |
| 11.2 | Хөгжимт жүжгийн театрын тайз дэлгэц, гэрэл гэрэлтүүлэг, хөгжим аппаратурыг шинэчлэх | ОНТ-100.0 | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 36.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, тоног төхөөрөмжийн хангалт 70 хувьтай байна. | Тоног төхөөрөмжийн хангалтыг 73 хувьд хүргэнэ. | Хөгжимт жүжгийн театрын зөөврийн лед дэлгэц нийлүүлэх ажлын хүрээнд 100.0 сая төгрөгийн өртөг бүхий техникийн тодорхойлолт болон холбогдох материалыг бүрдүүлж, худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус техникийн тодорхойлолтын дагуу тендерийн шалгаруулалт зохион байгуулагдаж, "Амжилтын нар" ХХК 58.0 сая төгрөгийн үнийн саналаар шалгарч гэрээг байгуулсан бөгөөд нийлүүлэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хийхээр төлөвлөж байна. | 100 |
| 11.3 | Тусгай хамгаалалтын бүсэд байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлан таниулах | ОНТ-50.0 | Олон нийтэд суталчилсан цуврал нэвтрүүлэгийн тоо | 2 нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргүүлсэн. | 3-аас доошгүй нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргүүлсэн байна. | Аймгийн нутаг дэвсгэрт орших Улсын болон аймгийн хамгаалалтад байх нийт 53 дурсгалаас 50 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах чиглэлээр гурвласан гэрээг холбогдох байгууллага, харьяа нутгийн захиргааны байгууллага болон дурсгалт объект байрлах газрын хариуцагчтай байгуулан, гэрээний дагуу хамгаалалтын ажлыг зохион байгуулан ажиллаа. | 70 |
| 11.4 | Нүүдэлчин Монгол" фестиваль арга хэмжээнд уран бүтээлчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилах , | ОНТ, Төсөл хөтөлбөр | Оролцсон арга хэмжээний тоо, оролцсон иргэдийн тоо | Нүүдэлчин Монгол – 2024 арга хэмжээнд Булган аймгаас 40 хүний | "Нүүдэлчин Монгол" олон Улсын фестивальд 45-аас доошгүй хүний | "Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль"-д аймаг, орон нутгаа төлөөлөн оролцохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тус арга хэмжээ 2025 оны 08 дугаар сарын 21- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Улсын хэмжээний баяр наадамд аймаг орон нутгийн өв соёлыг сурталчлан таниулан оролцоход дэмжлэг үзүүлэх. | 15.0 | | бүрэлдхүүнтэй баг амжилттай оролцсон. | бүрэлдэхүүнтэй баг төлөөлөн оролцсон байна. | 24-ний өдрүүдэд зохион байгуулагдах бөгөөд аймгийн төлөөлөл болох 45 хүний бүрэлдэхүүнтэй багийг бүрдүүлж, оролцох урлаг, соёлын үзүүлбэр, үндэсний өв уламжлалыг таниулах үзэсгэлэн, гар урлалын бүтээл, үндэсний хувцас, уламжлалт зан үйл, наадгайн тоглоом зэрэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| Зорилго:5. Орон нутгийн онцлогт түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 12 | **Зорилт: 12. Аймгийн соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, нутгийн иргэдэд түшиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | **УТ,ОНТ-288.0** | **Төсөлд хамрагдсан өрхийн тоо,Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хүрэлцэн ирсэн жуулчдын тоо, сургалтад хамрагдсан аж ахуй нэгжийн тоо** | **2 эвент арга хэмжээг зохион байгуулж, 180530 жуулчин хүрэлцэн ирж үзэж сонирхсон.** | **“Нэг өрх- Жуулчин гэр” НИТАЖ төсөлд 100-аас доошгүй өрхийг хамруулж,2-оос доошгүй эвент арга хэмжээг зохион байгуулж, 181530 жуулчин үзэж сонирхсон байна. Аж ахуй нэгжийг чадавхижуулах сургалтад 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулсан байна.** | **"Нэг өрх – Жуулчин гэр" төслийн хүрээнд Сэлэнгэ сумын иргэн Б.Отгончимэг гэр жуулчны үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэн, "Зочлох үйлчилгээний сургалт" үйл ажиллагаанд хамрагдаж, гэр барих, тохижуулах бэлтгэл ажлыг эхлүүлж, ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн хүн төрөлхтний жагсаалтад бүртгэгдсэн “Шагайн харваа” өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулах зорилгоор “Хангинахын шугуйн шагайн тойром-2025” эвент үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Мөн "Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв" ГҮТББ, Аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгууллаа.** | **81.2** |
| 12.1 | “Нэг өрх- Жуулчин гэр” НИТАЖ төслийг хэрэгжүүлнэ. | ОНТ-10.0 | Хамрагдсан өрхийн тоо | - | 100-аас доошгүй өрхийг хамруулсан байна. | "Нэг өрх – Жуулчин гэр" төслийн хүрээнд Сэлэнгэ сумын иргэн Б.Отгончимэг гэр жуулчны үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэн, "Зочлох үйлчилгээний сургалт" үйл ажиллагаанд хамрагдаж, гэр барих, тохижуулах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Цаашид орон нутгийн аялал жуулчлалын хөгжилд хувь нэмэр оруулах, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэхээр ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12.2 | Улсын болон орон нутгийн чанартай эвент арга хэмжээг зохион байгуулах | ОНТ-256.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хүрэлцэн ирсэн жуулчдын тоо | 2 эвент арга хэмжээг зохион байгуулж, 180530 жуулчин хүрэлцэн ирж үзэж сонирхсон. | 2-оос доошгүй эвент арга хэмжээг зохион байгуулж, 181530 жуулчин үзэж сонирхсон байна. | “Хангинахын шугуйн шагайн тойром-2025” эвент үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, Архангай, Булган, Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Орхон, Сэлэнгэ, Төв аймгийн нийт 250 гаруй ахмад болон залуу харваачид оролцож, цэц мэргэнээ сорилоо. Тус арга хэмжээг салбар бүрийн 40 гаруй албан хаагчид хамтран зохион байгуулж, хяналт тавьж ажиллалаа.12 сумын Соёлын төвөөс нийт 13 удаа Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэнг зохион байгуулж, 74 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн металл урлал, модон эдлэл, зөөлөн эдлэл, уран дархан, эсгий урлал, арьс ширэн урлалын бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. “Айраг фестиваль” эвент арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөж байна. | 70 |
| | | | | | | хуралд оролцож, МУ-ын орон нутгуудаа төлөөлөн үг хэлэв. Мөн хурлын үеэр Ляонин муж болоод Аншань хотуудтай уулзалт хийсэн. Уулзалтын үр дүнд талууд харилцан айлчлал хийж, цаашид аж үйлдвэр, ухаалаг хөдөө аж ахуй, хүнд хөнгөн аж үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологиос туршлага судлах зэргээр хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар тохиролцлоо. Энэхүү ажлын мөрөөр хамтран ажиллах саналыг боловсруулан Ляонин муж болон Аншань хотын захиргаанд хүргүүллээ. 5 дугаар сард Улаан-Үүд хотноо зохион байгуулагдсан “Ялалтын баяр”-т АЗДТГ-аар ахлуулсан 5 төлөөлөгч оролцож, томилолтын хугацаанд ХАА-н коллежид суралцаж буй оюутнуудтай уулзаж, хичээлийн явц, тулгарч буй асуудлыг сонсоны үр дүнд талууд гурвалсан гэрээг дүгнэж, цаашдын арга хэмжээг тодорхойлохоор болсон. 6 дугаар сард Закамень аймгийн “Сурхарбан”, “Эв модны наадам”-д ХЭЗХ-ийн даргаар ахлуулсан Тэшиг сум, Номын сангийн төлөөлөгчид буюу нийт 25 төлөөлөгч оролцов. | |
| 37.2 | Гуравдагч улс орнуудтай явуулж буй боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлалын салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх | 90.0 | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 5 | 7 | БНСУ-ын Асан хотын Хусогийн их сургуульд 4 дүгээр сард хийсэн албан уулзалтаар талууд оюутан элсүүлэх, ЕБС-ийн багш нарыг чадавхжуулах, сурагчдыг Солонгос улсын сургуулийн орчин нөхцөлтэй танилцах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхээр тогтож, 7 дугаар сарын эхэнд “БНСУ-ын бүрэн дунд боловсролын хөгжил, өнөөгийн байдал, сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах” сэдвээр Солонгос улсад зохион байгуулагдах 4 өдрийн сургалтад манай аймгийн 34 багш, мэргэжилтэн хамрагдахаар бэлтгэл хангаж байна. Мөн 4 дүгээр сарын айлчлалаар Шинхан их сургуульд суралцаж буй 64 оюутантай уулзаж, тэдний санал хүсэлт сонсон, суралцах амьдрах орчин нөхцөлтэй танилцсан бол 6 дугаар сард Хусогийн их сургуульд хийсэн айлчлалаар ирэх хичээлийн жилд Булган аймгаас оюутан хөнгөлттэй нөхцөлөөр элсүүлэхээр тогтсон. Аймгийн Засаг даргын орлогчийн 5 дугаар сард БНСУ-ын Дэгү хотноо хийсэн албан томилолтын үр дүнд Дэгү хотын боловсролын газартай шууд харилцаа тогтоож, чансаа өндөр их сургуулиудтай хамтран ажиллах, сургалтын хөтөлбөр, лаборатори, дадлагын орчин, цахим сургалтын төв, дэд бүтэцтэй газар дээр нь танилцах, Булган аймгийн сургуулийн өмнөх боловсрол болон ЕБС-ийн багш нарыг богино болон урт хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, сурагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын эхлэл тавигдсан. Асан хоттой тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд Асан хотын Эрүүл мэндийн төвөөс бага насны хүүхдийн шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх “Шүд зайлах аппарат”-ыг манай аймагт нийлүүлж, бүх сумдын ЕБС-д байрлуулах ажил эхэлсэн бол Имбон эмнэлгийн эмч нарын баг Булган аймагт ажиллах, эрүүл мэндийн байгууллагын менежментийг сайжруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, аймгийн нарийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжлийн эмч нарыг тус эмнэлэгт богино хугацаагаар дадлагажуулах, эрүүл мэндийн аялал жуулчлал зохион байгуулах юм. Асан хотын Хөдөө аж ахуйн технологийн төвтэй тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Политекник коллежийн дэд бүтцэд тулгуурласан 4 улирлын ухаалаг хүлэмжийг орон нутагтаа нэвтрүүлж, салбарын хүний нөөцийн сургалтыг тус төвд зохион байгуулахаар бэлтгэл хангаж ажиллаж байна. Япон улсад суугаа МУ-ын ЭСЯ-аар дамжуулан Хоккайдо мужийн Хигашикава хоттой харилцаа тогтоохоор ажиллаж байгаа бөгөөд Баян-Агт сумын Засаг дарга 6 дугаар сарын эхэнд тус Япон улсад ажиллаж, эхний ээлжийн туршлага судлах үйл ажиллагаанд оролцоод ирсэн бөгөөд хоёр орон нутаг шууд харилцаа тогтоосноор гоймонгийн үйлдвэр, хог боловсруулах үйлдвэрийг орон нутагтаа нутагшуулах ажлыг хэрэгжүүлэх юм. | |
| 37.3 | МУ дахь ЭСЯ, Олон улсын байгууллагуудтай явуулах харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх | 30.0 | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 2 | 6 | ТИКА ОУБ болон манай аймгийн хамтын ажиллагааны хүрээнд тус байгууллагаас Политехник коллежийн гал тогоонд 550 сая төгрөгийг өртөг бүхий тоног төхөөрөмжийн дэмжлэг олгогдсон байна. МУ-д суугаа АНУ-ын Элчин сайдын урилгаар 7 дугаар сард зохион байгуулагдах Америк улс байгуулагдсаны 249 дэх жилийн тэмдэглэлт ойн баярт аймгийн Засаг дарга оролцох бэлтгэлийг хангаж байна. Энэ оны 7 сард зохион байгуулагдах аймгийн Баяр наадам, Баян-Агт сум байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадам, 8 дугаар сард зохион байгуулагдах “Айрагны баяр”-уудад Дархан хот дахь ОХУ-ын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ерөнхий консулын газар болон уламжлалт харилцаат БНБУ-ын Закамень аймаг, БНСУ-ын Асан хотын ИТХ-ын төлөөлөгч, Япон улсын Хоккайдо мужийн төлөөлөл хүрэлцэн ирж оролцохоор төлөвлөж байна. | |
| 38 | **Зорилт: 38. “Төрийн албаны стандартыг хэрэгжүүлнэ.”** | 22.5 | 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2022 онд стандарт нэвтрүүлсэн | 100 хувь | 2020-2024 онд АЗДТГ, НДХ, ОБГ, Хангал, Тэшиг, Гурванбулаг, Булган, Дашинчилэн, Хутаг-Өндөр, Бүрэгхангай сумд стандарт нэвтрүүлсэн бөгөөд баталгаажуулалтын хугацаа дууссан сумдад дахин баталгаажуулах аудитад хамрагдахаар бэлтгэл ханган ажиллаж байна. СХЗГ-аас 6 дугаар сарын эхэнд “MNS 7068:2025 Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага стандарт”-ыг баталсан. Үүний хүрээнд төрийн байгууллагуудад төрийн албаны стандарт нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэн ажиллана. | 40 |
| 38.1 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Чанарын багийн 2025 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах | 21.0 | 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2023 онд 100 хувь | 100 хувь | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Чанарын багийг шинэчилж, 2025 онд хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг АЗДТГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 30 хувьтай. | 50 |
| 38.2 | ISO 9001:2015 стандартын баталгаажуулах аудитад хамрагдах | 1.5 | Баталгаажуулах гэрчилгээ | 2022 онд стандарт нэвтрүүлж, гэрчилгээ авсан | Баталгаажуулах гэрчилгээ авсан байна | ISO 9001:2015 стандартын баталгаажуулах аудит хийгдэх ажлыг “Кю Сертф”ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр ажиллаж байна. 3 дугаар улиралд багтаан баталгаажуулалтад хамрагдана. | 30 |
| 39 | **Зорилт 39. Төрийн үйлчилгээг цахимжуулна** | **120,0** | **2025 оны төлөвлөгөөний** | **-** | **50 хувь** | **Төрийн үйлчилгээг цахимжуулах, оновчлох, загварчлах, нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн үйлчилгээний нэгдсэн системд** | **70** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **хэрэгжилтийн хувь** | | | **холбох зорилгоор орон нутгийн чанартай төрийн 8 байгууллагын 63 үйлчилгээг И-Монголиа платформд холбосон. Операторын горимоор иргэдэд 43 байгууллагын 451 төрлийн үйлчилгээ үзүүлдэгээс 7159 үйлчилгээ , ухаалаг хурдан киоск машинаас 60 байгууллага 600 гаруй үйлчилгээ үзүүлдгээс 1924 үйлчилгээг нийт 9083 үйлчилгээ үзүүлсэн.** | |
| 39.1 | Төрийн үйл ажиллгаагааны хурд бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх “Цахим Булган” хөтөлбөр боловсруулна | 60,0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | 50 хувь | "Цахим Булган" хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж төлөвлөгөө боловсруулан ажилласан. Хөтөлбөр боловсруулахтай холбоотой арга хэмжээнүүдийг төлөвлөн Засаг даргын 2024-2028 он хүртэл хэрэгжих мөрийн хөтөлбөрт тусгасан. Хөтөлбөр боловсруулах ажлы хэсэг 2 удаа хуралдаж, нийт төрийн болон төрийн өмчит байгууллагуудаас 2 удаагийн судалгаа авч, хөтөлбөрийн төсөлд саналуудыг тусгаж ажилласан. Мөн бусад аймгуудын туршлагыг судалсны үр дүнд хөтөлбөрийн төслийг боловсруулсан болно. Аймгийн иргэдийн төлөөлөөгчдийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулна | 70 |
| 39.2 | "SMART BULGAN' гар утасны аппликэйшний дахин хөгжүүлэлтийг хийх. | 60,0 | Апп-д холбосон төрийн үйлчилгээ | орон нутгийн 61 үйлчилгээ | 63 үйлчилгээ | Цахим Булган хөтөлбөр ньАймгийн ИТХ-аар хэлэлцүүлэгдэн баталгаажсаны дараагаар “Смарт Булган” апп-ын ажил хэрэгжиж эхэлнэ. Хөтөлбөрийн төсөлд тусгагдсан болно. | 70 |
| 40 | **Зорилт 40. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.** | 29.0 | Ил тод байдлын үнэлгээний хувь | 70,24% | 80 % | Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 176 байгууллага шилэнд бүртгэхээс 127 байгууллага бүртгүүлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 2025 оны 1 улирлын байдлаар 51 байгууллага 98 төрлийн мэдээ | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийн баяжуулалт хийж, https://shilen.gov.mn/ сайтад байршуулан ажилласан. | |
| 40.1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагуудын мэдээллийг shilen.gov.mn цахим хуудсаар байнга ил тод нээлттэй байлгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Ил тод байдлын үнэлгээний хувь | 70,24% | 80 % | Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 176 байгууллага шилэнд бүртгэхээс 127 байгууллага бүртгүүлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 2025 оны 1 улирлын байдлаар 51 байгууллага 98 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, https://shilen.gov.mn/ сайтад байршуулан ажилласан. 2-р улирлын тайланг баталгаажуулалт 7 сарын 1-ний өдрөөс 8 сарын 15-ны хооронд хийгдэнэ. Аймгийн ил тод байдлын үнэлгээг ЦХИХХЯ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулатын газраас гаргах бөгөөд хагас жилийн байдлаар аймгийн дундаж үнэлгээ гараагүй байна. | 70 |
| 40.2 | Засаг даргын дэргэдэх Мэдээлэл технологийн "Хурдан" клубийг байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх, сургалт сурталчилгаа хийх | 29.0 | Клубд элссэн сурагчдын тоо | 100 хүүхэд | 150 хүүхэд | Булган аймгийн Засаг даргын дэргэдэх ХУРДАН хүүхдийн клубыг 2024 оны 12 сарын 26-ны өдөр байгуулсан бөгөөд байгуулагдсан цагаасаа хойш клубын гишүүн хүүхдүүд улсын чанартай тэмцээн уралдаанд амжилттай оролцож байна. 2025 оны 01 сарын 24-26-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор Монгол Улсад анх удаа “Дронкон” нисгэгчгүй нисэх хэрэгсэл жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцон дэд байр эзлэн, туршлага хуримтлууллаа. Цаашид гадаад, дотоодын хэмжээнд зохион байгуулж буй уралдаан тэмцээн идэвхитэй хамрагдах болно. Одоогоор аймгийн төвийн 100 хүүхэд гишүүнээр элссэн бөгөөд цаашид сумдын хүүхдүүдэд сургалт сурталчилгаа хийж элсүүлнэ. | 70 |
| 41 | **Зорилт: 41. Төрийн байгууллагад хандсан** | - | **Хүлээн авч шийдвэрлэсэ** | **Нийт 4503** | **3000** | **16 сум, 1 тосгон, 24 агентлагт ирсэн ирсэн өргөдөл гомдлыг Засгийн** | **90** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх”** | | **н өргөдөл, гомдлын тоо** | | | **газрын 11-11 утсаар, бичгээр, болон тамгын газрын нэлттэй утас 7034-7034 утсаар хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа.** | |
| 41.1 | Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл гомдол хүсэлтийг шуурхай шийдвэрлэнэ. | - | Ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо<br><br>Шийдвэрлэлтийн хувь | Бичгээр 3618<br><br>Шийдвэрлэлт 85% | 2000 өргөдлийг судлан шийдвэрлэж хариуг хүргүүлсэн байна. | Иргэдээс төрийн байгууллагад ирсэн өргөдө гомдлыг утсаар, цахимаар, бичгээр тус тус хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. Аймгийн хэмжээнд нийт 1010 өргөдөл гомдол ирснээс Аймгийн ИТХ-д 3, АЗДТГ-т 118, агентлагт 206, 726 өргөдөл, гомдол ирсэн. Эдгээр өргөдөл гомдлын шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл албан бичгээр 317, цахимаар 155, утсаар 199, бичгээр 181 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Хугацаа болооогүй 123 өргөдөл, гомдол байна. | 90 |
| 42 | **Зорилт 42. Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах** | | **Хугацаа хоцроолгүй нэгтгэн тайлагнах** | **Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” 2024-2028 онд хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны хөтөлбөрийг батлуулсан.** | **Төлөвлөгөөний хэрэгжилтүүдийг хагас, бүтэн жилээр нэгтгэж, ХШҮХ хийлгэх** | **Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн 44 зорилтын 151 үйл ажиллагааны хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн ХШҮХ-т тайлагнасан. Мөн аймгийн Засаг даргын илтгэлийн нэгтгэлийг боловсруулав.** | **70** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 42.1 | Аймгийн Засаг дарга сум болон агентлагийн дарга нартай байгуулах хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих | | Гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан байна | Аймгийн Засаг дарга сумын Засаг дарга, агентлагийн дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээг 2024 оны 02 сарын 06-ны өдөр байгуулж, гэрээний төслийг нэгтгэн боловсруулах болон гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. | Хамтран ажиллах гэрээ болон Гүйцэтгэлийн тайланг хүлээн авч, ХШҮХ хийлгэх. | Аймгийн Засаг дарга сум, агентлагийн дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээг 2025 оны 01 сарын 20-ны өдөр байгуулж, гэрээний төслийг нэгтгэн боловсруулах болон гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. | 100 |
| 42.2 | Сумдын Засаг даргын Тамгын газар, агентлаг, байгууллагад тайлан мэдээ гаргахад зөвлөн туслах | | Журмын дагуу тайлангаа ирүүлсэн сум, байгууллагын тоо<br><br>Сум, агентлаг дүгнэгдсэн байдал | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу сум, агентлагуудад ажилласан. | Сум, агентлагуудад зөвлөн туслах ажиллагааг зохион байгуулж, тайлан мэдээний гүйцэтгэлд ахиц гаргана | Зөвлөн туслах үйл ажиллагаа хийгдэх ажлын төлөвлөгөө гараагүй хүлээгдэж байна. Өдөр тутамдаа сум, агентлагийн тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүдэд цахимаар болон утсаар холбогдон мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч ажилладаг | - |
| 42.3 | Аймгийн Засаг дарга салбарын сайдуудтай байгуулсан гэрээг хяналтад авч, хэрэгжилтийг тайлагнах процесст хяналт тавих | | Хугацаа хоцроолгүй тайлагнасан байх | Аймгийн Засаг дарга Монгол Улсын Шадар сайд, ЗГХЭГ-ын дарга болон 18 салбарын сайдтай байгуулсан гэрээг хугацаа хоцроолгүй холбогдох яамдад | Аймгийн Засаг дарга салбарын сайдуудтай байгуулсан гэрээг хяналтад авч, гэрээг тайлагнах хугацаанаас хоцроолгүй тайлагнасан байна. | Аймгийн Засаг дарга салбарын сайдуудтай 2025 онд хамтран ажиллах 20 гэрээг хяналтад авч, гэрээг тайлагнах хугацаанаас хоцроолгүй тайлагнахад анхаарч ажиллаж байна. 2025 оны хагас жилээр 11 гэрээг хагас жилээр хэрэгжилт тайлагнахаар байгааг хүлээн авч ХШҮХ-ээр ХШҮ хийлгэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүргүүлэн ажилласан. | | | |
| 42.4 | Төрийн шагналд уламжлах ажлыг зохион байгуулах, аймгийн шагналд уламжилж буй иргэдийн материалыг хүлээн авч, шаардлага хангасан иргэнд журмын дагуу шагналыг олгуулах ажлыг зохион байгуулах | | 600 орчим иргэдийг төрийн шагналд уламжилна<br><br>Аймгийн шагнал олгох журмыг шинэчлэн батлуулсан байх | 2024 онд 1100 орчим хүний шагналын материалыг хүлээн авч, цахим санд шивж оруулан, эх материалыг аймгийн Засаг даргын албан тооттой хамт Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлаад байна. 2024 онд аймгийн шагналаар шагнуулахаар 1300 гаруй хүний тодорхойлолт ирснээс шаардлага хангасан 1000 гаруй хүнд зохих шагналыг олгох ажлыг хийсэн. | 600 орчим иргэдийг төрийн шагналд уламжилж, эх материалыг МУ-ын ЕТГ-т хүргүүлж, программд шивж оруулна. Журмын дагуу аймгийн шагналыг олгох ажлыг зохион байгуулна. | Он гарсаар 600 орчим хүний шагналын материал хүлээн авснаас одоогоор 313 хүний материалыг шагналын программд оруулж, МУ-ын ЕТГ-т уламжлаад байна. Мөн энэ онд 100 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлэх Булган сумын 1 дүгээр сургуулийг "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон", Баян-Агт сумыг "Алтан гадас" одонгоор шагнуулахаар тус тус уламжлав. Энэ онд алдарт эхийн 1,2 дугаар одон авах 228 эхийн материалыг татан авч бүрдэл хэсгийн дутууг нөхөн бүрдүүлж, шивэлт хийн МУ-ын ЕТГ-т хугацаа хоцроолгүй өргөн барьсан. | 100 |
| 42.5 | Байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Б/51 дугаар тушаалаар байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь биелүүлэн ажилласан байна. | Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын төлөвлөгөөг батлуулан энэ онд 11 ажил хийхээр тусгасан. Байгууллагын үйлчлэгч, жолооч, жижүүрийн ажилтнуудыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах ажлыг НҮА-тай хамтран | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдал хариуцсан мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгэж байна. | | хэрэгжүүлж 3,1 сая төгрөгийн үнэ бүхий 40 ширхэг нормын хувцсаар хангасан. Ажлын байрны тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг стандартын дагуу мөрдөж ажиллах заавар зөвлөмжийг тогтмол өгч, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. | |
| 43 | Зорилт: 43. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх | | Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр-ийн хэрэгжилт үр дүнд хүрсэн байдал | *2024 он - 91.1 хувь, 2023 оны жилийн эцэс - 94.74 хувь, 2024 оны жилийн эцэс – 93.41 хувь* | 70.0-аас доошгүй хувь | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрт тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 25 үр дүнгийн хэрэгжилт 40.4 хувь, хөтөлбөрийн 44 үр дүнгийн хэрэгжилт 51.5 хувь, 151 үйл ажиллагааны хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 50.3 хувьтай байна.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнөөс аймагт даалгасан 111 арга хэмжээг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системээр сум, байгууллагуудад хуваарилсан. 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй байна.<br><br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны 1 дүгээр сарын болон 1 дүгээр улирлын биелэлтэд хяналт шинжилгээ хийж, 78.33-88.59 хувьтайгаар хяналт-шинжилгээ, үнэлгээний “Мэдээллийн цахим сан”-д хугацаанд нь байршуулсан. Мөн Засгийн газрын 2016 оны 285 дугаар тогтоол, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, цахим системээр тайлагнав. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны эхний хагас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн биелэлтийг тайлагнах хугацаа болоогүй байна. | |
| 43.1 | Бодлогын бичиг баримтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнах | | Бодлогын баримт бичгийн хэрэгжил-тийн хувь | *ЗГ*<br>*2024 он - 91.1 хувь*<br>*ЗД*<br>*2023 оны хагас жил 61.1 хувь, 2023 оны жилийн эцэс 90.5, 2024 он - 91.9 хувь* | 70.0-аас доошгүй хувь | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрт тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 25 үр дүнгийн хэрэгжилт 40.4 хувь, хөтөлбөрийн 44 үр дүнгийн хэрэгжилт 51.5 хувь, 151 үйл ажиллагааны хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 50.3 хувьтай байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнөөс аймагт даалгасан 111 арга хэмжээг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системээр сум, байгууллагуудад хуваарилсан. 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй байна. | 100 |
| 43.2 | Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнах | | Тогтоол шийдвэр-ийн хэрэгжил-тийн хувь | *2023 оны жилийн эцэс - 94.74 хувь, 2024 оны жилийн эцэс – 93.41 хувь* | 70.0-аас доошгүй хувь | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны 1 дүгээр сарын болон 1 дүгээр улирлын биелэлтэд хяналт шинжилгээ хийж, 78.33-88.59 хувьтайгаар хяналт-шинжилгээ, үнэлгээний “Мэдээллийн цахим сан”-д хугацаанд нь байршуулсан. Мөн Засгийн газрын 2016 оны 285 дугаар тогтоол, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, цахим системээр тайлагнав. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг тайлагнах хугацаа болоогүй байна. | 100 |
| **44** | **Зорилт: 44. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Амар тайван Булган” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.** | **22.0** | **Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь** | **0** | **80** | **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Амар тайван Булган” хөтөлбөрийн төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаар** | **94** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **хэлэлцүүлэн 2025 оны VII/38 дугаар тогтоолоор батлуулан ажилласан. Хөтөлбөрийг 2025 онд 3 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг тусган хэрэгжүүлэхээр боловсруулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжаар 2025 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 40 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.** | |
| 44.1 | Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2 удаа нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах | 4.0 | Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь | Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 10.4 хувиар өссөн байна. | Гэмт хэргийн илрүүлэлтийг 5 хувьд хүргэнэ. | Аймгийн хэмжээнд “Сар шинэ 2025” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд мал хулгайлах гэмт хэрэг ихээр үйлдэгддэг Бүрэгхангай, Сайхан, Баян-Агт, Баяннуур зэрэг сумдтай хил залгаа аймгийн Цагдаагийн газрын алба хаагч нартай хамтарсан хөдөлгөөнт болон постын хяналт шалгалтыг 11 удаа 7-14 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Энэ хугацаанд нийт 8 холбогдогчтой 16.401.264 төгрөгийн хохиролтой мал хулгайлах 7 гэмт хэрэг илрүүлсэн. Дээрх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 4 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Малчдын гар утсанд үүрэн телефоны “Unitel”-ийн “Websms2” модем ашиглан “Малчин та өөрийн мал сүргээ байнгын хариулга маллагаатай байлгаж, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ үү” гэсэн масс мессеж хүргэх ажлыг хэсэгчилсэн байдлаар 3 удаа зохион байгуулсан. Аймгийн Цагдаагийн газрын сумдын тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нартай хамтран туслах малчнаар ажиллаж байгаа нийт 18 иргэний судалгааг шинэчлэн гаргаж **Patrol2.police.gov** цахим санд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэж, тэдэнд тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br><br>Мөн мал хулгайлах гэмт хэрэг ихээр бүртгэгддэг Сайхан, Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн зэрэг сумуудад малчны 4 бүлгийг шинээр байгуулсан. Малын хулгайн гэмт хэрэг 2025 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. | |
| 44.2 | Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тандалт судалгаа хийж, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 4.0 | Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн өсөлт бууралтын хувь | 2024 оны байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 1 хувиар буурсан | гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралт 2 хувь буурсан байна. | Гэр бүлийн хүчирхийлэл дахин үйлдэж болзошгүй 195 иргэнийг нэг бүрчилсэн хяналтад авч хувийн хэрэг нээж одоогоор гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэж болзошгүй 13 иргэн хяналт тавьж дахин зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.<br>Аймгийн Цагдаагийн газарт хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага ECS программд 101 бүртгэгдсэнээс 100 хувь хохирогч, холбогдогчийн регистрээр шивж оруулсан.<br>Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэгийг олон нийтэд түгээх зорилгоор ЕБС-ийн сургуулийн 1959 сурагч, 2361 иргэнд “Хүүхдийн эрх хамгаалал”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Гэр бүлийн тухай хууль”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр 4 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хэргээр буюу 25 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. | 100 |
| 44.3 | Хүүхдийн эрх зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тандалт судалгаа хийж, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 4.0 | Хүүхдийн эрхийн зөрчлийн өсөлт, бууралтын хувь | Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 хувиар буурсан. | Хүүхдийн эрхийн зөрчлийг 5 хувиар бууруулна | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар 34 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад төрийн байгууллага 44, төрийн бус байгууллага 9, аж ахуйн нэгж 14, ерөнхий боловсролын сургууль 22, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэцэрлэг 16 хамрагдаж, нийт төрийн алба хаагч 3027, малчин 982, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 761, ажилгүй 495, оюутан, сурагч 2178 хамрагдсан байна. Булган сумын 6 багийн нийгмийн болон сумын нийгмийн ажилтан нартай хамтран ЕБС-ийн сургуулийн 60 хүүхдийг хамруулсан “Хүүхдээ сонсъё” арга хэмжээг зохион байгуулж, “Хүүхдийн эрх хамгаалал” сэдвээр сургалт зохион байгуулсан.<br>Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэлд хийгдсэн аюулын зэргийн үнэлгээ өндөр гарсан 3 дуудлага мэдээлэлд харьяа багийн Засаг дарга болон аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт албан бичгээр мэдэгдэж тухай бүр холбон зуучилж ажилласан.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар хүүхдийн эрхийн зөрчил 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр буюу 16,7 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. | |
| 44.4 | Мансууруулах бодис хэрэглэгч, архинд донтогчдод эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах | 5.0 | Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтын хувь | Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 13 хувиар буурсан байна. | Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2 хувиар буурсан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар “Архинаас татгалзъя ” сэдэвт хэлэлцүүлгийг аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зохион байгууллаа.<br>Хэлэлцүүлэгт Булган сумын багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, төрийн бус байгууллага, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй цэгүүдийн төлөөлөл, төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан нар хамрагдлаа. Мөн 3 сумын Засаг даргын Тамгын газар, “АА” цуглаан хамтарч архины хамааралтай 17 иргэнийг гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2 удаа 6 цагийн сургалтыг зохион байгуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагтай хамтарч “Сайн дурын эмчилгээ” тусгай арга хэмжээг энэ оны 03 дугаар сард зохион байгуулж, Булган сумын 6 багийн 12 иргэний өөрсдийн гаргасан хүсэлтийн дагуу архинаас гарах сайн дурын эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан. Энэ оны 1 дүгээр улиралд архины хамааралтай, архинд донтох эмгэгтэй 13 иргэнийг шүүхийн шийдвэрээр архины албадан эмчилгээнд хамруулсан.<br>Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 40 бүртгэгдэж 55 хувиар өссөн. | |
